



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

**Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө
бүртгэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 2,260,100,000.00 (хоёр тэрбум хоёр зуун жаран сая нэг зуун мянга) төгрөгийн үнэ бүхий (Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын) Эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3. Хөрөнгийн давхар бүртгэлийг залруулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

133005979
22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 28 ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ /ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ/-ЭЭР БАРЬСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ /БАРИЛГА БАЙГУУЛАМЖ/-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /тегрөг/	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (иж бүрдэл)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 20 ортой, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 25.0м*14.8м				
2	Уурын зуухны барилга	Тэнхлэгээрээ 6.0м*6.0м, 1 давхар, зоорийн давхаргүй,	2,260,100,000.00	2023.02.28	ББКД-67-09/23	Эрүүл мэндийн төв (Хөвсгөл аймаг Эрдэнэбулган сум)
3	Цогцос хадгалах байр	Тэнхлэгээрээ 10.8м*6.0м, 1 давхар, зоорьгүй				
НИЙТ ДҮН			2,260,100,000.00 (хоёр тэрбум хоёр зуун жаран сая нэг зуун мянга)			